

**МОНОС ХҮНС ХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧИН,  
НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ  
ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Монос Хүнс ХК-ийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэм болон засаглалын (БОНЗ) суурь үнэлгээг “Ризилиенс Консалтинг Сервиз” ХХК -аар хийж гүйцэтгүүлсэн. Үнэлгээ хийхдээ НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд (ТХЗ), Олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын түгээмэл мөрддөг Байгаль орчин, Нийгэм, Засаглалын шаардлагууд болох Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК): Байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн стандарт, Европын холбооны Тогтвортой байдлын тайлагналын стандарт конвенц, тунхаглал болон Монгол Улсын холбогдох хууль, стандарт, журамд заасан шаардлагуудыг шалгуур болгон авч үзсэн.

**БАЙГАЛЬ ОРЧИН**


**НИЙГЭМ**

**ЗАСАГЛАЛ**

*БОНЗ нь тухайн байгууллагын дотоод ба гадаад орчинд үзүүлж буй нөлөөллийг үнэлэх багц шалгууруудаас бүрддэг.*



Байгаль Орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын суурь үнэлгээг нийт 225 шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд **153 ШАЛГУУР БҮРЭН БИЕЛСЭН**, 24 шалгуур бүрэн бус, 48 шалгуур биелээгүй байна. БОНЗ-ын үнэлгээний шалгууруудыг нэгдсэн оноогоор авч үзвэл нийт арван оноо авах ёстойгоос 6.9 оноог авсан байна.



“...Үнэлгээний үр дүнгээс харахад “МОНОС ХҮНС” ХК нь нийгмийн хариуцлагаа ухамсарласан, үйл ажиллагаандаа БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН хувьд АРВИН ОЛОЛТ АМЖИЛТТАЙ, үйл ажиллагаа нь САЙН дадалтай байна...”

Ризилиенс Консалтинг Сервиз ХХК



Засаглал



Нийгэм



Байгаль орчин



# БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТ



Уур амьсгалын  
өөрчлөлт, хүлэмжийн  
хийн ялгаруулалт



Байгалийн нөөцийн  
ашиглалт (эрчим  
хүчний үр ашиг,  
усны менежмент )



Экологийн ул мөр  
(хог хаягдлын  
менежмент,  
биологийн олон янз  
байдал)



Бохирдол (агаар, ус,  
хөрс)

Байгаль орчны үнэлгээг хийхдээ хууль эрхзүйн баримт бичиг, бодлогын баримт бичиг, удирдамжуудын хүрээнд гол элементүүд болох Хаягдалгүй эдийн засаг (Circular economy), биологийн олон янз байдал, орчны бохирдол, уур амьсгалын өөрчлөлт гэсэн 4 үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд нийт 44 дэд үзүүлэлтээр үнэлгээ хийж үзэхэд 22 шалгуур бүрэн биелсэн, 4 шалгуур бүрэн бус биелсэн, 18 шалгуур биелээгүй байна.




Уур амьсгалын  
өөрчлөлт



Биологийн олон янз  
байдал



Хаягдалгүй эдийн засаг



Орчны бохирдол

Орчны бохирдол болон Хаягдалгүй эдийн засаг хэсгүүдэд нь БОННУ (Байгаль Орчин Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ) хийлгэж түүний дагуу жил бүр БОМТ (Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө) баталж хэрэгжүүлдэгтэй холбоотой мөн Хаягдалгүй эдийн засгийн загварын хувьд аливаа үйл ажиллагааг төлөвлөлтийн шатанд нь хаягдлыг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах арга хэмжээг төлөвлөж, үйл явц болон технологийг төлөвлөдөг байна.





ХАБЭА гүйцэтгэл



Жендер ба хүйсийн  
ялгаатай байдлын  
талаар баримтлах  
бодлого



Хүний эрх



Хөдөлмөрийн  
стандарт



Ажилчдын сургалт,  
хөгжлийн хөтөлбөр



Ажилчдын оролцоо



Хэрэглэгчийн  
сэтгэл ханамж



Олон нийтийн  
харилцаа

# НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийгмийн үнэлгээг хийхдээ ажиллах хүч, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нөлөөлийн бүсийн оршин суугчид, хэрэглэгчид, хүнсний аюулгүй байдал, чанар, тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага гэсэн 6 үндсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд нийт 119 дэд үзүүлэлтүүдээр үнэлсэн. Эдгээр шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхэд **92 ШАЛГУУР БҮРЭН БИЕЛСЭН**, 10 шалгуур бүрэн бус, 17 шалгуур биелээгүй ба компанийн хувьд нийгмийн чиглэлийн үйл ажиллагаа нь харьцангуй **САЙН** байна.


Нийгмийн үнэлгээгээр **ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ**, чанар, **ХЭРЭГЛЭГЧИД**, Нөлөөллийн бүсийн оршин суугчдын хувьд **ӨНДӨР** оноо авсан. Энэ нь ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, ISO22000:2018 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны стандартуудыг амжилттай хэрэгжүүлсний үр дүн юм.



Ажиллах хүч



Хөдөлмөрийн аюулгүй байдал



Нөлөөллийн бүсийн оршин суугчид



Хэрэглэгчид



Хүнсний аюулгүй байдал, чанар



Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага



# ЗАСАГЛАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ



Хувьцаа эзэмшигчийн  
эрх (ТУЗ, Гүйцэтгэх  
удирдлага, Аудитын  
хорооны бүтэц)




Хээл хахууль,  
авилгын эсрэг  
бодлого



Эрсдэлийн  
удирдлага



Татварын ил тод  
байдал



Бизнесийн ёс  
зүй



Хяналт,  
тайлагнал



Лобби үйл  
ажиллагаа



Оролцогч  
талуудын  
харилцаа



Компанийн хувьд засаглалын зарчмуудыг баримталдаг, удирдлага болон тайлагнал тогтолцоо сайтай нь байгууллагыг төлөвшүүлж, үйл ажиллагаа харьцангуй тогтвортой байгааг харуулж байна.

Компанийн засаглалыг үнэлэхдээ хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, компанийн ёс зүй ба соёл, оролцогч талууд, үйл ажиллагааны тайлагнал ба ил тод байдал, хяналтын тогтолцоо, гүйцэтгэх удирдлага гэсэн 7 үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд нийт 62 дэд үзүүлэлтүүдээр үнэлсэн.

Компанийн засаглалын үнэлгээгээр Гүйцэтгэх удирдлага, ТҮЗ, Тайлагнал, Ил тод байдал, Хяналтын тогтолцооны хувьд дунджаас дээгүүр оноо авсан нь байгууллагын дээд удирдлагын түвшинд ойлголцол, **МАНЛАЙЛАЛ САЙТАЙ, ШИЙДВЭР ГАРГАЛТ ХУРДАЙ, ХЭРЭГЖҮҮЛЭЛТ ХЯНАЛТТАЙ, ИЛ ТОД ТАЙЛАГНАЛТАЙ** байдал нь гүйцэтгэлийг сайжруулж үйлдвэрлэлийн гарц болон үр ашиг нэмэгдэх боломжийг богино хугацаанд бүрдүүлдэг.

ЕХТБТС (ESRS 2022) (Европын Холбооны Тогтвортой Байдлын Тайлангийн Стандартууд) удирдамжид засаглалын хүрээний эрсдэлүүдийн хувьд улс төрийн үйл ажиллагааны ба лобби бүлгийн санхүүжилт, авлига, шүгэл үлээгчийг хамгаалах бодлого, компанийн ёс зүйн бодлого, тогтолцоо зэрэгт илүү голчлон төвлөрсөн байдаг бол ОУСК-ын хувьд ТҮЗ-ийн хараат бус гишүүд, аудитын хорооны гишүүдийн мэдлэг, дотоод аудитын нэгж, авлига-мөнгө угаалт, эцсийн өмчлөгчийн мэдээллийн нээлттэй байдал, ногдол ашгийн бодлого зэргийг илүү чухалчилж дунд, урт хугацааны эрсдэлүүд дотор хамгийн “өндөр”-т эрэмбэлсэн байдаг. “Монос Хүнс” ХК-ийн засаглалын хувьд мөнгө угаалт, шүгэл үлээх бодлогыг боловсруулан баримтлаж ажиллахыг зөвлөсөн байна.



Хувьцаа эзэмшигч, Оролцогч талууд



ТҮЗ, Гүйцэтгэх удирдлага



Компанийн ёс зүй



Үйл ажиллагааны тайлагнал



Хяналтын тогтолцоо (Эрсдэл)





## БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ ТӨЛӨВШСӨН

Компанийн ТҮЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа нь жигдэрсэн, баримт бичгийн бүртгэл, хяналт, хадгалалт сайн. “Бизнесийн Ёс зүйн хэм хэмжээ” баримт бичигт Компанийн үйл ажиллагаанд баримтлах үндсэн зарчмыг тодорхойлсон. Энэ нь итгэлцэл хүндлэл дээр суурилсан ажил хэрэгч хамтын ажиллагааны суурь болсон байна.



## НИЙГЭМД ЭЕРГЭЭР НӨЛӨӨЛӨГЧ

Нийгмийн эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн үйлдвэрлэх салбарт үндэсний болон олон улсын стандартыг мөрдөж ажиллах тал дээр салбартаа жишиг байгууллага болсон. Бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдалд анхаардаг төдийгүй нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх контент сурталчилгааг байнга хөгжүүлж сурталчилж нийгэмд эерэгээр нөлөөлж ажилладаг.

## ХАРИУЦЛАГАТАЙ АЖИЛ ОЛГОГЧ


Ажилтнууд ОУ-ын сайн туршлагуудаас сурч хөгжих, хувь хүний үнэ цэнээ нэмэгдүүлэх, албан тушаал ахихад нь тэгш боломжоор хангаж дэмжин ажилладаг. Залуучуудын ажил хөдөлмөртөө өсөн дэвжих боломжийг нэн түрүүнд тавьж, тэднийг сургах хөгжүүлэхэд, харилцааны соёлд сургахад ихээхэн анхаарч ажилладаг.





## НИЙГМИЙН ОЛОН ТАЛТ, ЯЛГААТАЙ БАЙДЛЫН ОРОЛЦОО, ТЭГШ БОЛОМЖИЙГ ХАНГАГЧ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлэн нийгмээрээ хүлээн зөвшөөрөхөд дэмжлэг болгон ажилладаг. Өрх толгойлсон эмэгтэйчүүд, ахмад насныханд ажиллахад таатай ажлын байр бий болгож тэдний өрхийн орлогыг нэмэгдүүлэхээс гадна, нийгэмд өөрийн байр суурийг олох, нийгмийн идэвхитэй гишүүн байх боломжийг бүрдүүлж байна. Энэ нь нийгмийн олон талт, ялгаатай байдлын оролцоог нэмэгдүүлэх, тэгш боломжийг хангахад оруулж буй том хувь нэмэр юм.



## БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЭМЛЭГЧ

Үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг бүтээлчээр эрэлхийлж, хог хаягдлын менежментийг сайжруулах, байгалийн нөөцийг зөв зохистой хэрэглээг дээшлүүлэх, хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад хувь нэмэрээ оруулж ажиллаж байна.



МОНГОЛ ОЮУН САНААГ ТҮГЭЭГЧ



SGS Certified

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ЦЭНЭГЛЭГЧ

**МОНОС**  
ХҮНС